# МОНГОЛ УЛС
# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 27 өдөр Дугаар 1/234 Есөнбулаг сум

## Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Аймаг орон нутгийн нийгэм, эдийн засгийн суурь судалгааны мэдээ, мэдээллийг нэгтгэж, хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах, хууль, журамд нийцүүлэх ажлын хүрээнд цахим болон танхимын хосолсон сургалтыг авах ажлыг "Гранд нова грэйт" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэжаргал)-д олгосугай.

2.Шаардагдах 15,800,000 (арван таван сая найман зуун мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

8000010403

000, 007, 16